МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

“КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ” УТҮГ-ЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

"КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ" УТҮГ-ЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 25-ны өдөр №... Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" УТҮГ-ын төлөвлөгөөнд туссан 8 зорилтын 39 арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын үнэлгээний арга зүй болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

"Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв" УТҮГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 39 арга хэмжээний биелэлтийг 2025 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүнтэй байна.

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100%-ийн биелэлттэй – 33 арга хэмжээ;
2. Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90%-ийн биелэлттэй -2, 66,66 %-ийн биелэлттэй – 1 арга хэмжээ;
3. Эрчимжүүлэх шаардлагатай шатанд байгаа буюу 30% гүйцэтгэлтэй- 3 арга хэмжээ;
4. Үр дүн гараагүй буюу 0%-ийн гүйцэтгэлтэй – 0 арга хэмжээ;

Үнэлгээ хийгдсэн арга хэмжээний дунджаас үзвэл байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 93.25 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна гэж үнэлэгдлээ.

"Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв" УТҮГ нь иргэн, хуулийн этгээд, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хувийн хэвшлийн байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер халдлага, зөрчилд өртсөн дэд бүтэц, мэдээллийн системийг нөхөн сэргээхэд мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий хүний нөөц, техник, технологийн чадавх, мэдээллийн санг бэхжүүлэх үндсэн зорилгоор ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд тус газрын төлөвлөсөн 8 зорилтын 39 арга хэмжээнээс амжилттай хэрэгжиж буй дараах арга хэмжээнүүд байна гэж үзлээ. Үүнд:

Зорилт 4-ийн арга хэмжээ 4.5-д *"Кибер халдлага, зөрчлийн талаарх дуудлага, мэдээлэл хүлээн авах сувгуудын тасралтгүй ажиллагааг хангах"* төлөвлөгөөний биелэлт амжилттай хэрэгжиж байна. Тодруулбал "Тайлант хугацаанд 113 тусгай

дугаараар нийт 2,446 дуудлага хүлээн авснаас нийтийн төвд хамааралтай 836 дуудлага бүртгэгдэж, 146 байгууллагад хортой кодын илрүүлэлт болон бусад шаардлагатай зөвлөмж, мэдээллийг хүргэн ажилласан ба 70001113 суурин утсаар нийт 4 дуудлага хүлээн авсан байна.

Мөн www.113.mn цахим хуудасны хэвийн, тасралтгүй ажиллагааг бүрэн ханган ажиллаж, тус цахим хуудсаар нийт 36 мэдээлэл хүлээн авсан байхаас 28 мэдээллийг иргэн, 8 мэдээллийг байгууллагаас тус тус ирүүлсэн байна.

-113 тусгай дугаарыг автомат хариулагчтай болгох судалгаа хийгдэж, 70001113, 260113 байгууллагын суурин утас руу дуудлага хийхэд IVR автомат хариултаар дамжин байгууллагын дотуур дугаар болох 11132 суурин утсанд дуудлага хүлээн авдаг болж кибер халдлага, зөрчлийн мэдүүлэг авах сувгийн тоог нэгээр нэмэгдүүлсэн.

-Фейсбүүк хуудасны чатбот хэсэгт кибер халдлага, зөрчлийн талаар мэдээлэл өгөх сувгийн дэлгэрэнгүй мэдээллийг автоматаар хариулж байх тохиргоог нэмсэн" гэжээ.

Зорилт 3-ын арга хэмжээ 3.1-д *"Эх сурвалжуудаас ирсэн мэдээллийг нэгтгэх, тайлан мэдээ боловсруулах үйл ажиллагааг автоматжуулах"* арга хэмжээ тодорхой үр дүнтэй хэрэгжиж байна. Тодруулбал: "Эх сурвалжуудаас ирсэн мэдээллийг нэгтгэх, задлан шинжлэх, тайлан мэдээ боловсруулах үйл ажиллагааг автоматжуулах зорилгоор дараах 3 системийг хөгжүүлж, ашиглалтад оруулсан болно. Үүнд:

1. Threat Intelligence Dashboard систем

Олон эх сурвалжаас (Shadowserver, Sinkhole, Kaspersky гэх мэт) ирсэн мэдээллийг нэгтгэн задлан шинжилж, кибер халдлагын төрөл, давтамж, аюулын түвшин, эх сурвалж, порт скан, outlier detection зэрэг аналитик мэдээллийг харуулдаг үндсэн систем.

Мөн Халдлагыг scan, malware, device, honeypot зэрэг өргөн хүрээнд ангилан харах, Sample татан авч дэлгэрэнгүй шинжлэх, Англи, Монгол хоёр хэлний дэмжлэгтэй, Light, Dark theme ашиглах зэрэг нэмэлт сайжруулалтуудыг хийсэн.

2. Аюулгүй, Zero Trust орчинд ажиллах TI платформ систем

Threat Intelligence Dashboard-ын суурь кодыг шинэчилж, Zero Trust архитектур, өгөгдөл болон тохиргооны шифрлэлт, программын бүрэн бүтэн байдлын шалгалт, Single Page Application (SPA) орчны гүйцэтгэл сайжруулалт (state management, memory leak бууруулалт) бүхий аюулгүй ажиллагааг хангасан платформ систем.

3. Тайлан автоматжуулалтын веб систем

Кибер аюулын талаарх долоо хоног тутмын тайланг автоматаар боловсруулах веб суурьтай дашбоард апп хэсгийн судалгаа, хөгжүүлэлтийг хийсэн. Тус системд С2 халдлагуудын мэдээллийг API хандалтаар татан авч дэлгэрэнгүйгээр харуулахаар оруулж, орчуулгыг хавсаргасан мөн хорт программын дотоод тархалтын мэдээллийг өдөрт нь автоматаар татан авч дата-г илүү нарийвчлалтай гарах боломжтой болсон." гэжээ.

Зорилт 6-ын арга хэмжээ 6.1-т *"Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайланг хүлээн авч зөвлөмж, шаардлага хүргүүлэх"* төлөвлөгөөний биелэлтийг "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудад шаардлага, зөвлөмж хүргүүлж, 2025 оны 03 дугаар сарын 11-ээс 11 дүгээр сарын 07-ны өдрүүдийн хооронд "ХАС БАНК" ХХК, "Магнай Трейд" ХХК, "Клин Энержи" ХХК-ийн Салхит салхин цахилгаан станц, "Баянзүрх эмнэлэг" ХХК, "Дата Бэйнк" ХХК, "Богд Банк" ХК, "Тээвэр хөгжлийн банк" ХК, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК, "Бүрэн скор ЗМС" ХХК, "Энержи Ресурс" ХХК, "Капитрон Банк" ХХК, "Юнител" ХХК, "Юнивишн" ХХК, "Ашид Капитал ББСБ" ХХК, "Ариг Банк" ХХК, "Хаан Банк" ХХК зэрэг нийт 20 (26%) байгууллагаас Мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайланг хүлээн авсан.

Мөн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг 2025 оны 03 дугаар сарын 11-ээс 11 дүгээр сарын 04-ний өдрүүдийн хооронд "Клин Энержи Ази" ХХК, "Чингис Хаан Банк"

ХХК, "Капитрон Банк" ХХК, "Грандмед эмнэлэг" ХХК, "Ариг Банк" ХХК, "Магнай Трейд" ХХК, "ХасБанк" ХХК, "Энержи Ресурс" ХХК зэрэг нийт 11 (14%) байгууллагаас тайлан хүлээн авсан.

Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага нь өөрийн хариуцсан мэдээллийн систем, дэд бүтцийн хэвийн найдвартай тасралтгүй байдлыг хангах, гэмтэл саатлын үед сэргээн ажиллуулах төлөвлөгөөтэй байх, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хуульд заасан хугацаанд хүргүүлэх тухай 01/100 дугаар албан бичгийг нийт 60 байгууллагад хүргүүлсэн. Мөн "Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайланг цахимаар хүргүүлэх, хүлээн авах, тайлангийн мэдээллийг ашиглах журам"-ын төслийг боловсруулан, хянуулж байна" гэжээ.

Зорилт 8-ын арга хэмжээ 8.1-д *"Кибер халдлага, зөрчил хүлээн авах сувгуудаар иргэд, хуулийн этгээд, хувийн өмчит онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудаас хүлээн авсан, хүргүүлсэн мэдээлэлд тулгуурлан кибер халдлага, зөрчилд шинжилгээ хийж хариу үзүүлэх"* төлөвлөгөөний биелэлтийг "Хуулиар хүлээсэн чиг үүрэгт хамааралтай халдлагад өртсөн нийт 43 байгууллагын мэдээлэл бүртгэгдэж, 2025 оны 02 дугаар сараас 12 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд 15 байгууллагад газар дээр нь очиж ажилласан бол 28 байгууллагад зайнаас хариу арга хэмжээ авч ажилласан. Мөн Монгол Улсын харьяалал бүхий 487 IP хаягийн хэрэглэгчийн мэдээллийн систем хортой кодын халдлагад өртсөнийг илрүүлж, интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран холбогдох эзэмшигчдийг тогтоон, үүнээс 146 IP хаягийн хэрэглэгчдэд хортой кодын халдлагыг таслан зогсоох, нөхөн сэргээх талаарх зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн ажилласан" гэжээ.

Зорилт 8-ын арга хэмжээ 8.2-т *"Хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээллийн сүлжээ, мэдээллийн системд эмзэг байдал илрүүлэх шалгалтыг тогтмол хийх"* төлөвлөгөөний биелэлтийг "Нийтийн төвд харьяалагдах халдлагын хаягуудад тулгалт хийж, эмзэг байдал илэрсэн 43 байгууллагад 2025 оны 02 дугаар сараас 12 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд 15 байгууллагад газар дээр нь очиж ажилласан бол 28 байгууллагад зайнаас хариу арга хэмжээ авч ажилласан байна" гэжээ.

Энэ мэтчилэн "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар нь Монгол улсын засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яамны дэргэд байгуулагдсан цагаас хойш тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж, үйл ажиллагаа нь жигдэрсэн байдалтай байна. Гэсэн хэдий ч уг төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтээс хангалтгүй биелэлттэй хэд хэдэн арга хэмжээ байгаа бөгөөд эдгээр арга хэмжээг 2026 онд төлөвлөгөөнд тусгаж, эрчимжүүлэх шаардлагатай болохыг онцолж байна. Үүнд:

Арга хэмжээ 4.1: "Dark Web орчинд кибер аюул заналын судалгаа хийх"

Арга хэмжээ 4.7: *"Өгөгдлийн сангийн сервер байгуулах"*

Арга хэмжээ 5.5: "Ерөнхий боловсролын сургуулийн "Мэдээллийн технологи" хичээлийн сургалтын хөтөлбөрт тусгах кибер аюулгүй байдлыг хангах талаар агуулга боловсруулж, холбогдох газарт санал хүргүүлэх"

Арга хэмжээ 6.2: "Төвийн үйл ажиллагаанд Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны MNS ISO/IEC 27001:2023 стандартыг нэвтрүүлэх"

Түүнчлэн тайланд төлөвлөгөөнөөс зөрүүтэй шалгуур үзүүлэлт тавьж биелэлтийг ирүүлсэн 1 арга хэмжээ байна. Үүнд:

Арга хэмжээ 4.6: Кибер халдлага, зөрчлийн бүртгэлийн системийг сайжруулах техникийн даалгавар боловсруулж, системийн сайжруулалтыг хийх арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг төлөвлөгөөнөөс өөрөөр бичсэн боловч үнэлгээнд өөрчлөлт оруулаагүй болно.

Иймд “Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-ын тайлантай холбоотойгоор дараах дүгнэлтийг гаргаж байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Тус газрын хувьд 2025 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас өгсөн зөвлөмжийг авч хэрэгжүүлсэн, биелэлтийг ирүүлэхдээ хийж гүйцэтгэсэн ажлын агуулгыг 2000 тэмдэгтэд багтаасан, тоо баримтийг дурдсан гэх мэт ахиц байгааг онцлох нь зүйтэй байна.

Гэсэн хэдий ч “Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-ын төлөвлөгөөний хугацааг хэт ерөнхий тавьснаас үүдэлтэй нийт ажлын биелэлт төдийлөн ахиц гараагүй асуудлууд байлаа.

Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 1-д:

“шалгуур үзүүлэлт” гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлтийг;

“суурь түвшин” гэж үйл ажиллагаа болон бодлогын баримт бичиг, хэрэгжиж эхлэх үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

“зорилтот түвшин” гэж тухайн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг ойлгоно гэж заасан.

Тус газрын хувьд төлөвлөгөөг хийхдээ шалгуур үзүүлэлтийг оновчтой тавиагүйгээс буюу зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “гүйцэтгэлээр” гэх мэт байдлаар тоон утгаар илэрхийлээгүйгээс үнэлэх боломжгүй байдал үүсгэлээ.

Түүнчлэн төлөвлөлтийн хувьд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын стратеги төлөвлөгөө болон улсын хэмжээнд хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын арга хэмжээг оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

Тодруулбал “Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ-ын 2025 оны төлөвлөгөөний биелэлт хангалттай хэрэгжиж байгаа боловч, тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанаас гадна яамны бодлого хэрэгжүүлэх хүрээнд нэн чухал ажлуудыг цөөн байлаа.

Мөн байгууллага дотооддоо хийж хэрэгжүүлэх ажлууд болон гадагш чиглэн гүйцэтгэх ажлын харьцааг зөвтгөж, нийгэмд үзүүлсэн эерэг, үр дүн бүхий байдлаар төлөвлөх шаардлагатай байна. Жишээлбэл тус газрын хүрээнд хийгдэж байгаа сургалт, дадлага сургуулилтууд, түүнчлэн товхимол, нийтлэл гаргах, тараах материал хэвлүүлэх үйл ажиллагаанууд нэг агуулгын хүрээнд гүйцэтгэгдэж байгаа мэт уншигдлаа.

Иймээс 2026 онд хийх төлөвлөгөө, тайлан болон арга хэмжээг идэвхжүүлж ажиллахтай холбоотой дараах зөвлөмжийг өгч байна.

ДӨРӨВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

1. Тайлангийн чанар, нотолгоог сайжруулах. Арга хэмжээ бүрийн тайлбар, шалтгаан, үр нөлөөг баримтаар баталгаажуулан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хялбар, нэгдмэл бүтэцтэй тайлагнах.

2. Шалгуур үзүүлэлтүүдийг арга зүйд нийцүүлэн тодорхойлох. Суурь болон зорилтот түвшнийг үр дүнгийн хувьд бодитой, хэмжигдэхүйц, тайлбар бүхий байдлаар төлөвлөх.

3. Төлөвлөгөөний хугацааг бодитой төлөвлөх. Хүрэх боломжит зорилтуудыг тусгаж, явцыг шалгуур үзүүлэлтийн тусламжтай тайлагнаж болохоор тусгаж хэвших.

4. 2026 онд шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг үр дүнд чиглэсэн байдлаар төлөвлөх. Малгай зорилтын хүрээнд хэд хэдэн арга хэмжээ болгож хуваахдаа агуулгаар нь нэгтгэх.

6. Төсвөөс шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, тооцоо судалгаанд үндэслэсэн баримтад тулгуурлан гаргаж, агуулгын хувьд тодорхой, ойлгомжтой, зорьсон үр дүндээ хүрсэн эсэх талаар тайлагнаж хэвших;

9. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дотооддоо хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийн хамт яаманд ирүүлж байх.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах, ирэх онд хэрхэн зөв төлөвлөх талаар талаар яамны Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.

-oOo-